

Ганжурыг орчуулахад Аюуш гүүшийн оролцсон тухай

Д.Бүрнээ (МУИС)

Аюуш гүүшийг 1587 онд санскрит, төвд үсгийг тэмдэглэх али, гали хэмээх галиг үсгийг зохиосон<sup>1</sup>, харчин нутгаас гаралтай болохыг бид мэдэх билээ. Харин түүний орчуулгын үйлсийн талаар тэмдэглэсэн зүйл бол Юань улсын нэрт орчуулагч Шаравсэнгийн монголчилсон "Банзрагч" их хөлгөн судрыг засаж орчуулсан, "Хутагт огторгуй газрын найман гэгээн их хөлгөн судар" –ыг анх монголчилсон<sup>2</sup>, Хутагт цагаан шүхэрт", "Хар хэл нэрт" зэрэг судар номыг орчуулсан тухай мэдээ юм<sup>3</sup>. Энэхүү өгүүлэлдээ бид Аюуш гүүшийн орчуулгын үйлсийг тодруулах тухайлбал Ганжурыг орчуулахад хэрхэн оролцсон тухай өгүүлэхийг зорьсон юм. Үүний тулд эн тэргүүн монгол түүхэн сурвалж бичгүүдэд энэ хэлмэрчийн талаар тэмдэглэсэн зүйлийг авч үзье. 17-р зууны монголын түүхэн сурвалж болох "Эрдэнийн товч"-д "тэндээс богд хамгийг мэдэгч Очирдара далай лам нь Алтан хаанаа "Мянган алтан хүрдэнийг эргүүлэгч чакраварди сэцэн хаан" хэмээн, Бошогт жононд "Чакраварди сэцэн жонон хаши хаан" хэмээн, Сэцэн хунтайжид урьд энэтхэг дэхи цол нь "Цогцосын зүрхэн сэцэн хунтайж" хэмээн, Сэцэн дайчинд тэр цолыг нь бүү орчуул хэмээж "Салжал дайчин" хэмээн, Очир түмэн хонжиноо "Гүнтин гүй он хонжин" хэмээн, Ашин ламд "Эцэг лам" хэмээн, Гүми багшид "Сога хонжин" хэмээн, Аюуш багшид Ананда гүүш" хэмээх цол соёрхсон тухай өгүүлжээ.<sup>4</sup> Энд өгүүлснээс үзвэл Далай ламаас монголын хаад ноёдод хэргэм цол өгөх тэр үед Аюуш гүүшид Ананд гүүш хэмээх цол соёрхсон байна.

17-р зууны "Чакравард Алтан хааны тууж" хэмээх түүхэн сурвалжид Хутагт Далай лам эхлэн гурван хутагтан...  
Баясгалант бурханы номуудыг орчуулж хэлмэрчилсний тулд

<sup>1</sup> Mongyol yanjuur danjuur-un yarᠰay/degedü dooradu/ Kökeqota, alus un bar-a keblel-ün qoriy-a, 2002, 32-р тал.

<sup>2</sup> S. Sečenbilig, Burqan-u šašin-u mongyol nom sudur-un toyimu /Mongyol burqan-u šašin-u uran jokiyaal-un sudulu/ öbur mongyol-un soyol-un keblel-ün qoriy-a, 1998, 318–320-р тал.

<sup>3</sup> Цагаансар, Али гали үсгийн судалгаа, УБ., 2005, 8-р тал.

<sup>4</sup> Саган сэцэн. Эрдэнийн товч, сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар хийсэн М. Баярсайхан, УБ., 2006, 152-р тал.

Багш Аюушийг Ананд Манзушири гүүш цол соёрхож

Багш нарын охь болговой гэж тэмдэглэжээ.<sup>5</sup> Энд өгүүлснээс үзвэл Аюуш багшид Ананд Манзушири гүүш хэмээх цолыг бурханы номыг орчуулсных нь төлөө соёрхож, багш нарын эрхэмд өргөмжилсөн ажээ. Далай ламаас Аюуш гүүшид Ананд гүүш буюу Ананд Манзушири гүүш хэмээх цолыг өргөсөн явдал бол 1578 оны орчим болсон бөгөөд энэхүү уулзалтын үеэр Далай ламаас Алтан хаан болон бусад ноёд түшмэд, хэлмэрч нарт цол хэргэм соёрхсон ажээ. "Чакраварди Алтан хааны тууж"-д өөр бас нэг мэдээ байгаа бөгөөд түүнд Аюуш гүүшийн Ганжурыг орчуулахад хэрхэн оролцсон тухай өгүүлжээ. Түүнийг эш татвал

"Түүний хойно Намудай сэцэн хаан

Жүнхэн хатан хунтайж гурвуул

Дээд богд хааны төрийг номын ёсоор явуулаад

Тэгш бурхан багшийн номлосон зуун найман

Ганжур номыг монголын хэлээр

Тэр цагт Ширээт гүүш цорж, Аюуш Ананд манзушири гүүш тэргүүтэн ба

Гайхамшиг гурван түмний хэлмэрч мэргэдээр

Хар барс жилээс улаан хонь жил хүртэл бээр

Хамаг номуудыг бүрэн төгс орчуулж бүрүүн<sup>6</sup> гэжээ.

Энд өгүүлсэн зүйлээс үзвэл Ширээт гүүш зэрэг нэрт хэлмэрч гүүш нартай хамтарч Аюуш гүүш Ганжурыг хар барс жилээс улаан хонь жил хүртэл буюу 1602–1607 оны хооронд орчуулжээ. Өөрөөр хэлбэл Аюуш гүүш төвд Ганжурыг орчуулахад Ширээт гүүшийн нэгэн адил чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Аюуш гүүшид гуравдугаар Далай ламаас Ананд гүүш буюу Ананд Манзушири гүүш хэмээх цол соёрхсон нь 1578 оны орчим тул 1602–1607 оны хооронд Ганжурыг орчуулахад оролцсон хүмүүсийг дурдсан энэхүү мэдээнд Аюуш гүүшийн нэрийг Далай ламаас соёрхсон тэр алдраар нь тэмдэглэсэн байна. Тиймээс ч Монгол Ганжурын гарчигт Аюуш гүүшийн нэрийг мөн энэ нэрээр тэмдэглэсэн бололтой. Тэгвэл бид Монгол дармал Ганжур болон ОХУ-ын Санкт-Петербург хот дахи Улсын их сургуулийн Дорно дахины факультетийн номын санд хадгалагдаж буй бичмэл Ганжурын гарчигт Аюуш гүүшийн нэрийг хэрхэн тэмдэглэснийг авч үзье. Үүний тулд БНХАУ-д 2002 онд хэвлэгдсэн монгол дармал Ганжурын гарчиг<sup>7</sup> болон оросын монголч эрдэмтэн З.К. Касьяненкогийн 1993 онд нийтлүүлсэн монгол бичмэл Ганжурын гарчиг буюу "Каталог Петербургского рукописного "Ганджура"<sup>8</sup> хэмээх номыг гол хэрэглэгдэхүүн болгон ашигласан юм. Тус хоёр гарчигт Аюуш гүүшийн нэрийг хэрхэн тэмдэглэснийг харьцуулан авч үзье.

<sup>5</sup> Чакраварди Алтан хааны тууж, хөрвүүлэг, тайлбар зүүлт, нэрийн хэлхээ хийсэн Д.Заяабаатар, УБ.,2006, 54-р тал.

<sup>6</sup> Чакраварди Алтан хааны тууж, хөрвүүлэг, тайлбар зүүлт, нэрийн хэлхээ хийсэн Д.Заяабаатар, УБ.,2006, 84-р тал.

<sup>7</sup> Mongyol yanjuur danjuur un yar᠙ay/degedü dooradu/ Köke qota, alus-un bar-a keblel ün qorigy-a, 2002.

<sup>8</sup> Каталог Петербургского рукописного "Ганджура", составление, введение, транслитерация и указатели З.К.Касьяненко.-М., 1993.

Бичмэл Ганжурын гарчиг	Дармал Ганжурын гарчиг
<p>621 /4/  Bodisung narun öber-e öber-e tonilqui dörben nom-i бүтүгекүй neretü yeke köлgen sudur /кол./: ...tegünü qoyina oi Mongyol ulus-tur čakiby-a varti qutuy-tu dayiming sečen činggis qotala-yi жүг-i ilaydayči dai tayisung qayan-u jarliy-iyar: yeke-de nayirayuluyči: čoski oser blam-a-tur sitüjü: <i>Ananda güši</i> orčiyuluyad: qamuy amitan dürben nom-luy-a tegüskü boltuyai:</p>	<p>1006  Bovadhi satuva nar-n anggida tonilqui dörben nom-i бүтүгекүй neretü yeke köлgen sudur /γарγалγ-a/...  Монгол орчуулагчийн тухай мэдээ байхгүй</p>
<p>623 /6/  Qutuytu dörben nom-i uqayulqui neretü yeke köлgen sudur /кол./: Qotala жүг-үд-i ilayuyči qutuy-tu bayatur čikirvan qayan-u jarliy-iyar yeke nayirayuluyči čoski oser darqan lam-a-tur sitüjü <i>Ananda güüši</i> orčiyuluyad: Sančın ubasi: Dayičing kiy-a baysi qoyar bišibeі</p>	<p>1007  Qutuy-u dörben nom uqayulqui neretü yeke köлgen sudur /γарγалγ-a/... Qotala жүг-үд-i ilayuyči qutuy-tu bayatur čigiray qayan-u jarliy-iyar yeke nayirayuluyči čoski odser darqan blam-a-dur sitüjü mongyol-un kelen dur <i>Ananda güüši</i> orčiyuluyad: Sečen ubasi: Dayičing kiy-a baysi qoyar bičibeі</p>
<p>624 /7/  Qutuy-du oroi tayan erdeni-tü-yin öčigsen neretü yeke köлgen sudur /кол./: ...qotal-a үжүг-i boyda bayatur činggis qayan-u jarliy-iyar: ...erdem-ten-ü manglai čoski odser darqan lam-a bandiu guuši-tur sitüjü: öčüken oyun činege-ber <i>Ananda ayusi güüši</i> orčiyuluyad: Sečın ubasi dayičing kiy-a baysi qoyar biyibeі...</p>	<p>0840  Qutuy-tu oroi-tayan erdeni-tü-yin öčigsen neretü yeke köлgen sudur /γарγалγ-a/...ene sudur-i Gundga odser mergen manjuširi bandi da mongyolčilan orčiyulbai</p>
	<p>0882  Qutuy-tu `erdeni γarqu-yin oron neretü yeke köлgen sudur /γарγалγ-a/... yeke-de nayirayuluyči kelemörči čoski od ser darqan blam-a-dur sitüjü: <i>Ananda güüsi</i> orčiyuluyad Sečen ubasi Dayičing kiy-a baysi qoyar bičibeі...</p>
<p>740 /1/  Burqan-u /sang/ nom aljiyas šayšabad-tan-i gesegeküi neretü yeke köлgen sudur /кол./:...mongyol-un kelen-tür <i>Ananda güši</i> Včir ubaši qoyar orčiyulbai</p>	<p>0978  Burqan-u sang nom aljiyas šayšabad-tan-i gesgeküi neretü yeke köлgen sudur /γарγалγ-a/... mongyol-un kelen-dür <i>Ananda güüsi</i> Včir ubasi qoyar orčiyulba.</p>

741 /2/ Qutuy-tu qayan-tur soyugar soyuysan neretü yeke kölgen sudur /кол./: <i>Ananda güši</i> Oçir ubasi qoyar orçiyulbai	0979 Qutuy-tu qayan-dur soyugar[=süyüger] soyuysan neretü yeke kölgen sudur /γaryaly-a/... <i>Ananda güüsi</i> Oçir ubasi qoyar orçiyulbai
742 /3/ Qutuy-tu yuçin yurban dakin-u bölüg ner-e-tü yeke kölgen sudur /кол./: <i>Ananda güši</i> ubasi Oçir ubasi orçiyuluyad: orçiyuluyad tegüsbe	0981 Qutuy-tu yuçin yurban dakin-u bölüg ner-e-tü yeke kölgen sudur /γaryaly-a/... <i>Ananda güüsi</i> ubasi Oçir mongyol-un kelen dür orçiyuluyad tegüsgebei
743 /4/ Qutuy-tu ülemji çing sedkil-ün bölüg neretü yeke kölgen sudur /кол./:... Mongyol-un kelen-tür <i>Ananda güši</i> Vçir mergen ubasi qoyar orçiyulbai	0982 Qutuy-tu ülemji çing sedkil-ün bölüg neretü yeke kölgen sudur /γaryaly-a/... Mongyol-un kelen-dür <i>Ananda güsi</i> Vçir mergen ubasi qoyar orçiyulbai
745 /6/ Qutuy-tu sansar-i yegüdkeküi neretü yeke kölgen sudur /кол./:... Mongyol-un kelen-tür <i>Ananda güši</i> Vçir qoyar orçiyulbai	0984 Qutuy-tu sansar-i yegüdkeküi neretü yeke kölgen sudur /γaryaly-a/... Mongyol-un kelen-dür <i>Ananda güsi</i> Vçir qoyar orçiyulbai
747 /8/ Tegünçilen iregsen-i ögüleküi neretü yeke kölgen sudur /кол./:... Mongyol-un kelen-tür <i>Ananda güši</i> Mergen ubasi qoyar orçiyulbai	0987 Tegünçilen iregsen ögüleküi neretü yeke kölgen sudur /γaryaly-a/... Mongyol-un kelen-dür <i>Ananda güüsi</i> mergen ubasi qoyar orçiyulba
748 /9/ Yeke-de çiyuluysan-u yeke kölgen sudur-aça tegünçilen iregsen çoytu-yin tangyarilaysan neretü yeke kölgen sudur /кол./:...qutuy-tu dai ming çinggis qayan-u jarliy-iyar <i>Ananda güši</i> orçiyulbai	0988 Yekede çiyuluysan-u yeke kölgen sudur-aça tegünçilen iregsen çoytu-yin tangyariylaysan neretü yeke kölgen sudur /γaryaly-a/... qutuy-tu dai yuwan çinggis qayan-u jarliy-iyar <i>Ananda güüsi</i> orçiyulbai

Монгол Ганжурын гарчигт нэр дурдагдаж буй *Ananda güüši*, *Ananda ayusi güüši* нь нэрт хэлмэрч Аюуш гүүшийн алдар гэж үзвэл тэрээр бичмэл Ганжурт тэмдэглэснээр арван ном, дармал Ганжурт тэмдэглэснээр нийт есөн ном нийт 11 ном орчуулсан байна. Эдгээр нь:

1. Bodisung nar-un öber-e öber-e tonilqui dörben nom-i бүтүгекüi neretü yeke kölgen sudur
2. Qutuytu dörben nom-i uqayulqui neretü yeke kölgen sudur
3. Qutuy-du oioi tayan erdeni-tü-yin öçigsen neretü yeke kölgen sudur
4. Qutuy-tu erdeni γarqu- yin oron neretü yeke kölgen sudur
5. Burqan-u sang nom aljijas šayšabad-tan-i gesgeküi neretü yeke kölgen sudur
6. Qutuy-tu qayan-dur soyugar[=süyüger] soyuysan neretü yeke kölgen sudur
7. Qutuy-tu yuçin yurban dakin-u bölüg ner-e-tü yeke kölgen sudur

8. Qutuγ-tu ülemji čing sedkil-ün bölüg neretü yeke kölgen sudur
9. Qutuγ-tu sansar-i yegüdkeküi neretü yeke kölgen sudur
10. Tegünčilen iregsen ögüleküi neretü yeke kölgen sudur
11. Yekede čiyuluγsan-u yeke kölgen sudur-ača tegünčilen iregsen čoytu-yin tangyariγlaysan neretü yeke kölgen sudur

Эдгээр номоос таван судрыг ганцаар, зургааг бусадтай хамтарч орчуулжээ. Түүний хамтарч орчуулсан хүн бол Очир увш, очир мэргэн увш, мэргэн увш хэмээн нэр дурдагдаж буй хэлмэрч юм.

Бичмэл Ганжурт *Qutuγ-du oroi tayan erdeni-tü-yin öčigsen neretü yeke kölgen sudur*-ыг Ананд гүүш орчуулсан гэсэн бол дармал Ганжурын гарчигт Гунгаа–Одсэр мэргэн мандшир монголчилсон гэж байгаа юм. Ганжурын бүх орчуулгыг Гунгаа–Одсэр хянан шүүж ариутган зассан учир түүний нэрийг ийнхүү оруулсан бололтой. Нөгөөтэйгүүр бичмэл Ганжур дармал Ганжуртай яг адил биш. Монгол Ганжурыг хэвлэх үед засаж залруулсан зүйл байхаас гадна бас бичмэл Ганжурын зарим номын орчуулга дармал Ганжурынхаас өөр орчуулга юм.

Ганжурын төгсгөлийн үгд "yeke-de nayirayuluγči: čoski oser blam-a-tur sitüjü Ananda güši orčiyuluγad", "erdem-ten-ü manglai čoski odser darqan lam-a bandiu guuši-tur sitüjü: öčüken oyun činege-ber Ananda ayusi güüši orčiyuluγad" хэмээн Чойжи–Одсэр лам буюу Чойжи–Одсэр дархан ламыг шүтэж Ананд гүүш орчуулсан тухай дурджээ. Чойжи–Одсэр дархан лам гэж энд Ганжурын олон номыг орчуулсан нэрт гүүш Самдансэнгийг хэлж байгаа бололтой. Ганжурыг орчуулсан хэлмэрчидийн нэрийг хэдэн янзаар бичсэн байдаг. Тухайлбал: Самдансэнгийн нэрийг Чойжи–Одсэр Самдан дархан лам, Чойжи–Одсэр дархан лам бандида, Самдан дархан лам, Самдансэнгэ дархан лам, Самдан дархан лам, Санжаа сэнгэ гэж зэрэг хэдэн янз бичжээ. Нөгөөтэйгүүр дээр дурдсан судрыг "Mongγol ulus-tur čakiby-a varti qutuγ-tu dayiming sečen činggis qotala-yi jüg-i ilaydayči dai tayisung qayan-u jarliγ-iyar", "qotal-a üjüg-i boyda bayatur činggis qayan-u jarliγ-iyar" орчуулсан гэсэн нь Чингис хаан /1162–1227/ болон Тайсун хааны /1439–1452/ алдар гавьяаг алдаршуулан дуурсгах зорилгоос үүдэж тийнхүү бичсэн болов уу.

## RESUME

Mongolian sources of the middle ages such as "Chakravardi Altan khaanii tuuj" and "Erdeniin tovch" noted that Ayush guush was awarded with the title "Ananda Manzushiri Guush" by the Third Dalai Lama for his translation merit. Therefore, in the Colophon of Mongolian handwritten and printed Kanjur, we can see his name only under this title.

As noted Mongolian sources in Colophon of Mongolian Kanjur, he played a main role in the translation work of Kanjur together with the famous translator, Shireet guush. We found his name nine times in the Colophon of Mongolian handwritten Kanjur and ten times in the Colophon of Mongolian printed Kanjur. In total, he translated 11 works, out of which he translated 5 works by himself and 6 works with others. We think that the name, Choiji-Odser mentioned in the Colophon of Kanjur as a supervisor of Ayush Guush, is the famous translator Samdansengge.